Гарчиг

Оршил

1. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль болон судалж буй асуудалд холбогдох бусад хууль, эрх зүйн дэд актын биелэлтийн талаархи дүн шинжилгээ 3
2. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль болон энэ асуудалд холбогдох бусад хууль, эрх зүйн актын биелэлтийг хангах үүрэг бүхий байгууллагуудын / Цагдаагийн байгууллага, Оюуны өмчийн газар, Соёлын болон Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх зөвлөл/ хэрэгжүүлсэн ажиллагаа, тоо бүртгэл, мэдээ тайланд хийсэн дүн шинжилгээ 9
3. Садар самууныг сурталчилсан хэвлэл мэдээллийн тоо, хуульд тусгасан бусад шаардлагатай тоо баримтууд.....25
4. Садар самуун явдалтай тэмцэх талаар гадаадын зарим улсын хуулийн зохицуулалт.....29
5. Дүгнэлт.....37
6. Санал зөвлөмж.....40

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

Оршил

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас даалгасан “Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилт, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах” сэдэвт судалгааг баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

Энэхүү судалгаа нь 1998 оны 7 дугаар сараас мөрдөж буй Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн биелэлтийн төлөв байдал, хуулийг хэрэглэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлд дүн шинжилгээ хийж, садар самуун явдалтай тэмцэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах зорилготой байв.

Судалгааг гүйцэтгэхдээ шинжлэх ухааны арга зүйд тулгуурлах, бусдын нөлөөллөөс ангид байх зарчмыг баримтлан, сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ хийж, бодит байдлыг газар дээр нь ажиглан дүгнэх, ярилцлага, санал асуулга явуулах зэрэг аргыг ашиглав. Түүнчлэн энэ сэдвээр урьд гүйцэтгэсэн судалгааны тайлан, онол-практикийн хурлын илтгэл, бусад материалыг судлаж үзэв. Тухайлбал, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хэрэгжүүлж буй “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах” төслийн хүрээнд гүйцэтгэсэн Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн давхардал, зөрчил, хийдлийн судалгаа, Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгааны тайланг анхааран үзэж, холбогдох тоо баримт, дүгнэлтийг тус тус авч ашиглав.

Биеэ үнэлж явалдахтай тэмцэх талаар гадаад улсад баримталж буй бодлого, хуулийн зохицуулалтын онцлогийг судлан, тэдгээрээс БНСУ, Японы хуулийн зохицуулалтыг үндэсний зохицуулалттай харьцуулан авч үзэв.

Судалгааг ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторт Цагдаагийн академийн Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй ба криминалистикийн тэнхимийн багш, консогчдын оролцоотойгоор гүйцэтгэв.

Хууль зүйн үндэсний хүрээлэн
nlrc.gov.mn

НЭГ. САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ЭНЭ АСУУДАЛД ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ДЭД АКТЫН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР ДҮН ШИНЖИЛГЭЭ

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн биелэлт

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийг 1998 онд УИХ-аас батлан одоог хүртэл мөрдөж байгаа ч төдийлөн хэрэгжилт нь хангалтгүй байна. Уг хуулийг УИХ-аас 1995 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн дэг журмыг” хангах талаар авах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн төслийг боловсруулсан.

Тус хуульд тухайн үед ардчилал, ил тод байдлыг далимдуулан зарим хууль тогтоомж боловсронгуй бус байгааг ашиглаж эмэгтэйчүүд биеэ үнэлэн явалдах[1], зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр илт садар самууныг сурталчлах явдал нэмэгдэж байсан. Тухайн үед мөрдөж байсан Захиргааны хариуцлагын тухай хуулиар садар самууныг сурталчлахыг хориглосон ба Эрүүгийн хуульд биеэ үнэлсэн хэрэгт захиргааны шийтгэлийн арга хэмжээ авагдсаны дараа 1 жилийн дотор дахин тийм зөрчил гаргах, биеэ үнэлэх газрыг зохион байгуулах, түүнд насанд хүрээгүй хүнийг татан оролцуулах, садар самууны холбогдолтой зүйлийг насанд хүрээгүй хүмүүст сурталчлах, тараах, борлуулах хэрэгт хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж байсан.[2] Гэтэл садар самуун гэсэн ойлголт нэг мөр болоогүй, биеэ үнэлсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тогтоогоогүйн улмаас дээрх хууль хэрэгжиж чадаагүй. Энэ нь бүхэлдээ садар самуун явдлыг хориглож, түүний нийгмийн аюул, тархалтыг хязгаарлах, эротик сурталчилгаа, үйлчилгээний

[1] Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” УБ,1966 он, 898 дахь, тал, **Явалдах гэдэг үгийг** 1. Явахын үйлдэлдэх хэв, 2. Хурьцал үйлдэх, сэм явалдах, гэж тайлбарласан байна. Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 3.1.2. “садар самуун явдал” гэж биеэ үнэлж явалдах,... гэж тайлбарласан байгаа нь хууль тогтоогчийн зүгээс уг үгийг хуулинд оруулсан байна. Харин хуулинд болон дээд шүүхийн тогтоолд уг үгийг тайлбарлаагүй.

[2] Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах төсөл /Садар самуунтай явдалтай тэмцэх тухай хууль/ Ажлын тайлан 2010 он

талаар журам тогтоож хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний эрх зүйн үндсийг тогтоох зорилготой. 1998 онд садар самуун явдлыг сурталчилсан аливаа үйлдлийг таслан зогсоох, гэмт явдалтай тэмцэх, эротик[3] үйлчилгээг цэгцлэх зорилгоор уг хуулийг УИХ-аас баталсан.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх гол байгууллага нь цагдаагийн байгууллага бөгөөд тус байгууллага нь энэ төрлийн зөрчил гаргасан этгээдийг тогтоох, хариуцлага тооцох, бүртгэл хийх үүргийг гүйцэтгэдэг бол садар самуун явдлыг сурталчилсан сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр явуулахгүй байх үүргийг Оюуны өмчийн газар хэрэгжүүлж байна.[4] Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар “Цагдаагийн байгууллага биеэ үнэлж явалдсан этгээдийн гаргасан зөрчлийн талаар түүний ажиллаж, суралцаж байгаа газрын захиргаанд, ажил, сургуульгүй буюу гэрийн тодорхой хаяггүй бол оршин суугаа газрын харъяа сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргад албан ёсоор мэдээлнэ” гэсэн. Гэвч энэ заалт төдийлөн сайн хэрэгжиж чадахгүй байна. 2010 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн захиргааны зөрчлийн мэдээллийн санг ЦЕГ-ын мэдээлэл, судалгааны төв дээр бүрдүүлж эхлээд байна.[5] Уг хуультай холбогдох хуулиуд нь:

- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Гаалийн тухай хууль;
- Зар сурталчилгааны тухай хууль;
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль;
- Гэр бүлийн тухай хууль;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль;

[3] Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа 1998 оны Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 3.1.3. “эротик” гэж гоо сайхны таашаал төрүүлэх зорилгоор хүний нүцгэн биеийг урлаг, уран сайхны хэлбэрээр үзүүлэхийг хэлнэ гэж тайлбарласан байна.

[4] Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах төсөл /Садар самуунтай явдалтай тэмцэх тухай хууль/ Ажлын тайлан 2010 он

[5] Мэдээллийг ЦЕГ-ын Нийгмийн хэв журам хамгаалах газрын мэдээнээс ишлэв.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

- Соёлын тухай хууль;
- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Шуудангийн тухай.

Садар самуун явдлыг хориглосон Монгол Улсын олон улсын гэрээ конвенц-4

1. Хүүхдийг худалдах, биеэ үнэлэх, садар самуунд татагдахаас хамгаалах тухай нэмэлт протокол
2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц 1999 оны 6 дугаар сарын 17-ны өдөр
3. Хүүхдийн эрхийн тухай конвенц 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр
4. “Хүүхдийг садар самууны зорилгоор ашиглахын эсрэг” Дэлхийн II их хурлаас батлан гаргасан Ёкохамагийн тунхаглал.

УИХ-аас гаргасан тогтоолын нэр: Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр батлах тухай 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 2.2.6.4-т “Эмэгтэйчүүд, хүүхдийг элдвээр дарамтлах, доромжлох, хүнлэг бус хандах, тарчилган зовоох зэрэг хүчирхийллийн бүх хэлбэр, тэдгээрийн шалтгааныг илрүүлэх арилгах талаар төрийн болон төрийн бус байгууллагын хамтын чармайлтыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон төрийн бус байгууллагын хамтын чармайлтыг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага болон Засгийн газрын түвшинд нэгтгэн зохицуулж, үр дүнг жил бүр мэдээлж байна. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах, биеэ үнэлэхийг албадах, хөлслөх зэргийг хатуу хориглохын хамт, тийм гэмт үйлдэлд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, хүчирхийллийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, байнгын хүчирхийлэлд өртөж болзошгүй эмэгтэйчүүд, хүүхдийг асран хамгаалах талаар гүйцэтгэх эрх мэдлийн зохих байгууллагуудын үүрэг хариуцлагыг дээшлүүлнэ”, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 2.2.6-т “Эмэгтэйчүүд, хүүхдийг хэрцгийлэх, доромжлох, тарчилган зовоох зэрэг

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

хүчирхийллийн бүх хэлбэр болон тэднийг худалдах, биеэ үнэлэхийг албадах, хөлслөх зэрэг гаж буруу замд татан оруулахаас сэргийлнэ" гэж тус тус заасан.

Засгийн газрын тогтоолууд:

Агуулга:

1. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг батлах тухай /Эротикийн сурталчилгаанд хяналт тавих зөвлөлийн ажиллах журам/ 1998 оны 10 дугаар сарын 14-ний өдөр №193

2. Төлөвлөгөө батлах тухай /Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө/ 2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр №17

3. Хөтөлбөр батлах тухай /Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр/ 1999 оны 12 дугаар сарын 29-ний өдөр №229

4. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалт, журам батлах тухай 2001 оны 3 дугаар сарын 14-ний өдөр №54

5. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай 2002 оны 12 дугаар сарын 4-ний өдөр №245

6. Хөтөлбөр батлах тухай /Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр 1999 оны 12 дугаар сарын 29-ний өдөр №229

Сайдын тушаал

Агуулга:

ХДХВ/ ДОХ-той тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний тухай 2004 оны 8 дугаар сарын 31-ний өдөр №197/

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

Дүгнэж үзэхэд:

Эдгээр хуулиуд нь Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд шууд холбогдож байгаа бөгөөд давхардал, хийдэл үүсгэж байгаа юм. Хуулиудын биелэлтэнд дүн шинжилгээ хийж үзэхэд, Садар самуунд холбогдох зүйл заалтууд нь давхардаж хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглох зохицуулалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд давхардсан байдаг. Мөн түүнчлэн Олон нийтийн радио телевиз нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн бөгөөд энэ үүднээс дээрхи зохицуулалт нь Олон нийтийн радио телевизийн тухай хуультай агуулгын хувьд ижил юм. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд гадаадын иргэнд хориглох зүйлийн талаар заахдаа садар самууныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхийг хориглосон бөгөөд энэ нь Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дах хэсгийн зохицуулалттай агуулгын хувьд ижил байна. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалж болохгүй гэж заасан нь садар самууныг түгээн дэлгэрүүлэхийн эсрэг зохицуулалт билээ. Садар самуун явдлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тохиолдолд гэм буруутай мэдээллийн байгууллагад хүлээлгэх хариуцлага нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалттай ижил юм. Садар самууныг сурталчилсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь Захиргааны хариуцлагын тухай хууль болон Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд өөр өөр байдлаар зохицуулсан байдаг тул энэ нь гэмт хэрэгтэнд ял завших бүрэн боломжийг бий болгодог. Мөн түүнчлэн садар самууныг сурталчилсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь Эрүүгийн хууль болон Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд өөр өөр байдлаар зохицуулсан байна. Биеэ үнэлэхийг зохион байгуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь мөн л Эрүүгийн болон Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд өөр өөр байдлаар зохицуулсан байна. Биеэ үнэлэх нөхцлийг бүрдүүлсэн, зохион байгуулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлд заасан нь энэ төрлийн зөрчил нь гэмт хэрэгт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nlrc.gov.mn

тооцогдохыг илэрхийлж байгаа бөгөөд Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт хүлээлгэх хариуцлагыг заасан байхад Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд уг зөрчлийг захиргааны зөрчилд тооцон захиргааны шийтгэл ноогдуулахаар заасан нь хоорондоо зөрчилдөж байна.

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд “Садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах дэмжихийг хориглоно” гэж заасан байдаг ба энэ төрлийн зөрчил гаргасан аж ахуйн нэгжийг торгоод өнгөрдөг нь ял завших, мөн түүнчлэн тухайн үйл ажиллагааг өөгшүүлэх нэг хэлбэр болж байгаа юм.

Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтсээс 2009 онд 53 аж ахуйн нэгжийг хамруулан шалгаж 3 зөрчил илрүүлэн холбогдох албан тушаалтныг 150.000 төгрөгөөр торгож ширээний үйлчлэгч ажиллуулдаг, тайчих үзүүлбэр үзүүлдэг 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоон, порнограф буюу садар самуун сурталчилдаг байсан 1 сүлжээг илрүүлэн холбогдох хүмүүст эрүүгийн хэрэг үүсгэн шалгасан байна.[6] Цагдаагийн байгууллагаас энэ мэтчилэн биеэ үнэлэх, садар самуун сурталчилах явдлыг таслан зогсоох үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа нь харагдаж байна.

Мөн Зар сурталчилгааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-д “Энэ хууль улс төр, шашин, сүм хийдийн сурталчилгаа, түүнчлэн худалдаа, арилжаа, аж ахуйн үйл ажиллагаатай холбоогүй мэдээ, мэдээлэл зарлалд хамаарахгүй” гэж заасан бөгөөд “энэ заалтын дагуу мессеж, ТВ чат, зар мэдээ, зарлал интернэт дэх блог зэрэг нь зар сурталчилгаанд хамаарахгүй” гэж заасан.

Гэтэл эдгээрээр дамжин хууль бус мэдээ, мэдээлэл олон нийтэд түгээгдэж байгаа бөгөөд үүнийг зохицуулах, хориглох шаардлага зайлшгүй байгаа юм.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

[6] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зарим асуудлууд 50 дахь тал 2010 он

2. САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ЭНЭ АСУУДАЛД ХОЛБОГДОХ БУСАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АКТЫН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН /ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР, СОЁЛЫН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГУУДЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛ/ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛЛАГАА, ТОО БҮРТГЭЛ, МЭДЭЭ

Цагдаагийн байгууллагын 2010 оны мэдээ тайлангаар:

Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль хэрэгжиж эхлээд 12 жил өнгөрч байна. 1998 онд садар самуун явдлыг сурталчилсан аливаа үйлдлийг таслан зогсоох, ийм явдалтай тэмцэх, эротик үйлчилгээг цэгцлэх зорилгоор Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийг УИХ-аас баталсан. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх гол байгууллага нь цагдаагийн байгууллага бөгөөд тус байгууллага нь энэ төрлийн зөрчил гаргасан этгээдийг тогтоох, хариуцлага тооцох бүртгэл хийх үүргийг гүйцэтгэдэг. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлд зааснаар “Цагдаагийн байгууллага биеэ үнэлж явалдсан этгээдийн гаргасан зөрчлийн талаар түүний ажиллаж, суралцаж байгаа газрын захиргаанд, ажил, сургуульгүй буюу гэрийн тодорхой хаяггүй бол оршин суугаа газрын харъяа сум дүүрэг баг хорооны Засаг даргад, эсхүл нийтэд албан ёсоор мэдээлнэ. Монгол улсын Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулинд биеэ үнэлэх болон биеэ үнэлэхийг зохион байгуулах харилцааг хориглосон зохицуулалтууд голчлон хуульчлагджээ. 2009 онд гэхэд л 500 гаруй удаа хэсэгчилсэн болон тусгайлсан арга хэмжээ зохион байгуулжээ. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Он	Бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг	Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулийн дагуу хариуцлага ногдуулсан	Дүүргийн ЦХ-ээс зохион байгуулсан шалгалтын тоо

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

		Торгууль: хүн/төг	Баривчилсан	
2008	27	87/ 4000.0 мянга	49	
2009	10	24/ 1195.0 мянга	58	508
2010	10	21/1365.0 мянга	26	

Дан ганц цагдаагийн байгууллага гэлтгүй энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудын гол зорилго бол биеэ үнэлэх явдлыг багасгах, арилгах, охид эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгөд өртөж хохирхоос урьдчилан сэргийлэх, биеэ үнэлэхийг зохион байгуулах явдлыг таслан зогсооход оршиж байгаа.[7] Дээрхи зорилгод хүрэхийн тулд энэ төрлийн харилцааг зохицуулсан хуулиудын үр нөлөөг тодорхойлох, дүн шинжилгээ хийж тусгайлан авч үзэх нь чухал гэж бодож байна. Цагдаагийн байгууллагаас мэргэжлийн хяналт, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран “Шөнийн сурвалжлага” “Эрвээхэй”[8] гэх мэт олны анхаарлыг татсан давхардсан шинжтэй олон арга хэмжээ явуулж биеэ үнэлэх үзэгдэлтэй холбоотой хуулийн зөрчлүүдийг илрүүлэх нэрээр нүүр царайг нь олонд илчилдэг, хохирогчийг баривчилдаг, торгодог явдал нь биеэ үнэлэгчдийн өндөр эрсдэлтэй байдлыг улам даамжруулж, аюулгүй байдлыг нь эмзэг болгож, цагдаа төрийн бусад байгууллагад хандах итгэл, боломжийг нь хааж байна. Өөрөөр хэлбэл биеэ үнэлэхтэй тэмцэх болон гэмт хэрэгтэй тэмцэх асуудлууд агуулга хэлбэрийн хувьд ондоо зүйл гэдгийг ойлгож арга барилаа өөрчлөх шаардлагатай тулгарч байна.[9] Тухайлбал,

1. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.1, 8 дугаар зүйлийн 8.1.1, 9 дүгээр зүйлд заасан үүргийн биелэлт хангалтгүй, зохион байгуулсан ажлын талаар ***нэгдсэн мэдээ мэдээлэл байхгүй.***

2. Биеэ үнэлж явалдсан зөрчилд захиргааны шийтгэл хүлээсэн этгээдийн талаарх тоо бүртгэлийг хууль зааснаар цагдаагийн байгууллага эрхлэн хөтлөх үүрэгтэй. Гэвч цагдаагийн байгууллагаас албан ёсоор авч, энэхүү тайланд

[7] Нийслэлийн цагдаагийн газар. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зарим асуудлууд УБ, 2010, 48 дахь тал
[8] Мөн тэнд 51 дэх тал
[9] Мөн тэнд 51 дахь тал

ашигласан тоо баримтаар сүүлийн 3 жилд дунджаар биеэ үнэлэгч 50 эмэгтэйд баривчлах шийтгэл ногдуулжээ /мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1-д зааснаар биеэ үнэлж явалдсан этгээдийг 15-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл хүлээлгэдэг/. Үүнээс үзвэл биеэ үнэлж явалдагчидтай үндсэндээ дорвитой хариуцлага тооцдоггүй байна.

Оюуны өмчийн газрын 2010 оны мэдээ тайлан:

Оюуны өмчийн газар нь 2010 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн үгэн зард хяналт тавихаа больсон бөгөөд үгэн зард тавих хяналтыг Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар үйл ажиллагааг нь хэрэгжүүлж байгаа болно. Уг байгууллага нь энэхүү хяналтыг хэрэгжүүлдэггүй бөгөөд үйл ажиллагааныхан нь чиглэл нь бараа үйлчилгээнд тавигддаг гэсэн болно.[10] Зар сурталчилгаанд тавих хяналт сул байгаагаас, үүний цаана хүний наймаа, биеэ үнэлэх явдал зэрэг гэмт хэргүүд илрэхгүй байх тохиолдол гарсаар байна. Мэдээ мэдээлэл хурдацтай тархахын хэрээр хууль бус зар сурталчилгаа ч тэр хэрээр тархана.

Монгол Улсын “Зар сурталчилгааны тухай хууль”-ийн холбогдох заалтуудыг зөрчиж, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, иргэдийн ашиг сонирхолд хохирол учруулах, хүүхэд залуусын хүмүүжилд сөргөөр нөлөөлөх хандлагатай хууль бус зар сурталчилгаа явагдаж байгааг таслан зогсоох, хуулийн дагуу арга хэмжээ авч, зөрчлийг арилгуулах зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газартай хамтран “ЗАР СУРТАЛЧИЛГАА” нэгдсэн арга хэмжээг 2010 оны 02 дугаар сарын 4-ний өдрөөс 8-ны өдрийг дуустал төв, орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийг хамруулан нийт орон даяар явуулжээ[11]. Өнөөдөр Монголын мэдээллийн зах зээлд тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хэвлэл мэдээллийн нийт хэрэгслийн 15 орчим хувийг телевиз эзэлж байна. 2001 оны хагас жилийн байдлаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд нийт 24 телевиз, 9 кабелийн телевиз албан ёсоор бүртгэгдэн тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа ажээ.[12]

[10] Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөөх газар 2011 оны мэдээнээс ишлэв
[11] Оюуны өмчийн газрын мэдээнээс
[12] “Компьютерийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн зарим асуудлууд эрдэм шинжилгээний өгүүлэл Г. Оюунболд “Хууль дээдлэх ёс сэтгүүл” 2008 он №2

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

Одоогоор тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа 241 мэдээллийн хэрэгсэлтэй, үүнээс: сонин 144, сэтгүүл 36, радио 27, телевиз 24 кабелийн телевиз 9 байгаа юм. Телевизүүд гадаад, дотоодын телевизийн бүтээлийг тэр бүр худалдаж авах санхүүгийн чадавхи султай байдаг ба ихэвчлэн программ солилцоо худалдааны аргаар авдаг ганц нэг бүтээлийг эс тооцвол ихэнхдээ чанар муутай видео кино, эсвэл хулгайн замаар хуулж бичсэн зарим бүтээлийг орчуулан гаргах байдалтай /нийтэд үзүүлж байгаа телевизүүдийн хөтөлбөрийн 25-57 хувь нь гадаадын телевизийн бүтээлийг орчуулан үзүүлдэг/ байна. Судалгаагаар нийт гарч байгаа кинонууд нь хүчирхийллийг шууд харуулсан, сурталчилсан, өөгшүүлсэн дэмжсэн хэдийд насны ангиллаар, онцлогоор яаж үзүүлэх талаар ямар нэг хязгаарлалтгүй байна.[13] Эндээс үзэхэд хууль бус зар сурталчилгаа болон янз бүрийн чанарын шаардлага хангахгүй кинонууд ихээр гарах болсон нь үүнд тавих хяналт сул байгаагаас үүдэлтэй гэж үзэж байна. Зар сурталчилгааны тухай хуулиар айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг хориглосон байдаг.

Соёлын болон Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх зөвлөл:

Эротик чиглэлийн хэвлэл, ном зохиол, кино дүрс, бичлэгт тавих хяналтыг эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёлын болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудын дэргэдэх зөвлөл хэрэгжүүлнэ. Зөвлөлийн ажиллах журам, бүрэлдэхүүнийг Засгийн газар батална. Засгийн газар батална гэж заасны дагуу Засгийн газар 2009 оны 82 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Эротикийн сурталчилгаанд хяналт тавих үндэсний зөвлөл”-ийг Зөвлөлийн дарга /Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга/, нарийн бичгийн дарга/ тус яамны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга/ болон бусад төрийн ба төрийн бус байгууллагын холбогдох албан тушаалтан,

[13] Мөн сэтгүүл

Хууль зүйн үндэсний хүрээлэн nli.gov.mn

мэргэжилтэн, чөлөөт уран зохиолч зэрэг нийт 12 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус зөвлөлийн эрх үүрэг нь Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т заасны дагуу дараахь эрх үүрэгтэй байна. Үүнд:

а/ эротик хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэгийг хянах;

б/ хэвлэн нийтлэх, нийтийн хүртээл болгох эсэх талаар шийдвэр гаргах;

в/ шаардлагатай гэж үзвэл маргаантай асуудлаар дүгнэлт гаргах эрх бүхий холбогдох мэргэжлийн хүмүүс, судлаачдыг оролцуулсан шинжээчийн хэсэг томилох тухай шийдвэр гаргах;

г/ хяналт тавих явцад Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөн нь илэрвэл холбогдох этгээдэд хариуцлага хүлээлгэх талаархи саналаа эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавих;

д/ эротикийн сурталчилгааг хууль тогтоомжид нийцүүлэн явуулах талаар санал боловсруулж холбогдох байгууллагад оруулах.

Зөвлөлийн ажиллах журмын нийтлэг үндэслэлээс 7 дугаар зүйл “Зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомжид нийцсэн шийдвэр гаргана. Шийдвэрийг тогтоолын хэлбэрээр гаргана”. Тус зөвлөл нь 2009 онд “Ноцтой мэдээ” сонины “Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн буланд нийтлэгдсэн өгүүллэгүүдийн талаар иргэний гаргасан гомдлыг хянан хэлэлцсэн байна. Мөн Лесбиян, Гей, Бисексуал, Трансжендер төв” гэсэн төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх эсэхэд хяналт тавьж ажилласан байна. Энэхүү зөвлөлийн үйл ажиллагааг эхлэлийн төдий гэж дүгнэж болохоор байна. Хэн нэг этгээдээс тус зөвлөлд санал хүсэлт, гомдол эс ирвэл зөвлөл үйл ажиллагаа явуулахгүй байж болохоор байна.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн гажуудал, өнөөгийн төлөв байдал:

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд “Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном, зохиол, кино дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг улсын хилээр нэвтрүүлж буй эсэх”-ийг судлахад сүүлийн 3 жилд улсын хилээр эротик чиглэлийн хэвлэл ном зохиол орж ирээгүй байна. Энэ нь садар самуун явдлын сурталчилгаа бага байна гэсэн зүйл биш бөгөөд кино дүрс бичлэг

Хууль зүйн үндэсний хүрээлэн
nli.gov.mn

2008 оны байдлаар Порно CD-79 ширхэг БУГГ-т хураан авч Гаалийн тухай хуулийн дагуу улсын орлого болгон шийдвэрлэсэн байна. 2009 онд Порно CD-15 ширхэг ЗҮГГ-т хураан авч Гаалийн тухай хуулийн дагуу улсын орлого болгон шийдвэрлэсэн 2010 онд DVD -1000 ширхэг ЗҮГГ-т илрүүлэн гэмт хэргийн шинжтэй тул шалгууллахаар Замын үүд сумын Цагдаагийн хэлтэст шилжүүлсэн. 2010 оны 7 дугаар сарын 07-ны өдөр №4/38 тогтоолоор Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйл, түүний хэрэгжилт

• ***Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг аймаг, нийслэлийн Засаг даргаас тогтоосон тусгай цэгт худалдах,***

• ***Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдахдаа албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, цэцэрлэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр, хүнс, барааны зах, худалдаа, үзвэр үйлчилгээний газар, гар дээрээс худалдах; 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүнд худалдахыг*** тус тус хоригложээ.

Судалгааны дүн:

1. Дүүргийн Засаг дарга нар эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдаалах тусгай цэгүүдийг товлож тогтоогоогүй, судалгаанд хамруулсан сонин, сэтгүүл борлуулдаг 106 цэгт ажиллаж байгаа хүмүүстэй ярилцлага хийхэд тэд энэ талаар ямар нэг ойлголтгүй байна.

2. Албан байгууллагын дотор биш боловч тэдгээрийн ойролцоо /50 м-ийн дотор/, хүнсний захууд, худалдааны төвд эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг зарж борлуулсаар байгаа нь ажиглалтын судалгаанаас илт байна. Харин Драгон, Тээврийн товчоо, Баянзүрхийн товчоо буюу хот хоорондын зорчигч тээврийн авто вокзалуудын орчмоор гар дээрээс сонин, сэтгүүл зарах явдал байгаа ч эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдаалж буй байдал ажиглагдсангүй. Түүнчлэн сургууль, цэцэрлэг, оюутан сурагчдын дотуур байрны орчимд энэ төрлийн худалдаа үйлчилгээ байхгүй байна. Энэ төрлийн худалдаа эрхлэгчидтэй уулзаж ярилцахад эротик дүрс бичлэг, кино зэргийг ямар нэгэн

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

тэмдэглэгээ байхгүй CD-д буулган шинэ CD-нүүдтэй хамт байлгаж худалдаалдаг бөгөөд түүнийгээ “00” кино гэж нэрийддэг болох нь ажиглагдав.

3. Судалгаанд тохиолдлоор сонгогдсон сонин, сэтгүүл борлуулах 106 цэгээс 65 цэг дээр илтэд бага насны хүүхэд бие даан биш боловч эцэг эх, ах, эгч нарын хамт борлуулалт хийж байгаа нь мөн ажиглагдав. Бага насны хүүхдээр худалдаа хийлгэж байгаа эсэхийг тандах зорилгоор 4 цэг дээр туршилт хийн “Янаг хорвоо”, “Үдшийн шивнээ”, “Үдшийн сонин” худалдаж авахад 3 цэг дээр худалдааг бага насны хүүхэд хийж байлаа.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйл, түүний хэрэгжилт

1.Эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг, тайчих урлаг, үзүүлэх тоглолт, уралдаан, тэмцээн, бусад үзвэрийг үзүүлэхэд соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас тусгайлан зөвшөөрснөөс бусад газарт энэ төрлийн кино, дүрс бичлэгийг үзүүлэх:

2. Телевизийн нийтийн сувгаар дамжуулах;

3. 18 насанд хүрээгүй хүнд үзүүлэхийг тус тус хоригложээ.

Судалгааны үр дүн:

1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгайлан зөвшөөрснөөс бусад газарт үзүүлж байгаа эсэхийг судлахад зөвхөн кино театр болон кино театруудын эргэн тойронд байрлах кабинтай жижиг газруудад гарч байна. Ийм төрлийн кино кабинуудад тухайн үзвэр үзэгч нь насанд хүрсэн байх тухай анхааруулга байхгүй нь ажиглагдаж байлаа.

2. Эротик дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхийг хориглосон заалтуудыг телевизийн нийтийн сувгаар дамжуулж буй эсэхийг судлахад насанд хүрэгчдэд зориулсан кино нь 3 бөөрөнхий гэсэн таних тэмдгээр ялгагддаг ба ихэвчлэн оройн цаг болон амралтын өдөр давамгайлан гардаг. Энэ таних тэмдгийг телевизүүд өөрсдөө ялгах тэмдгээр тэмдэглэдэг ба Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлд телевизийн нийтийн сувгаар дамжуулахыг хориглоно гэж заасан байдаг. Мөн садар самуун явдлыг сурталчилах гол хэрэгсэл нь интернэт сайтууд байдаг ба ихэвчлэн бага насны хүүхдүүд сайтуудаар зочилдог нь

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

интернэтээр биеэ үнэлэх, эротик кино үзэх явдлыг өөгшүүлэн энэ төрлийн гэмт хэрэг газар авахад нөлөөлдөг байна. Интернэтээр биеэ үнэлэх явдлын хохирогч нь 13-18 насны охид байгаа ба тэдгээр нь хүний наймаанд өртөх тохиолдол гарч байна[14]

3. Соёлын төв өргөө, МҮЭСТО, Драмын эрдмийн театр, Дуурийн театр зэрэг томоохон театр, төвүүдэд зарим тохиолдолд 20:00 цагаас хойш гарч байгаа үзвэр үйлчилгээнд насанд хүрээгүй хүнийг оруулахгүй гэж байгаа боловч тухайн үзвэр үйлчилгээнд орж байгаа хүмүүсийн бичиг баримтыг шалгалгүй зөвхөн гадна байдлаар нь дүгнэлт хийж оруулж байгаа нь учир дутагдалтай байна.

Харин Тэнгис, Өргөө, Соёмбо зэрэг кино театр энэ шаардлагыг огт тавьдаггүй нь тогтоогдлоо. Гэхдээ эротик кино гаргахдаа “зөвхөн насанд хүрэгчдэд” гэсэн тодотгол тавьж байна. Мөн тухайн киног үзэх гэж байгаа хүмүүсийн бичиг баримтыг үзэж шалгадаггүй, зөвхөн гадна байдлаар дүгнэлт хийж байгаа нь учир дутагдалтай байна. Биеэ үнэлэх, бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулах зохион байгуулах үйлдэл нь хэн нэгэн хүний ганц нэгэн удаагийн санамсаргүй тохиолдлын үйлдэл бус харин ашиг олох зорилгод хүрэх үүднээс төлөвлөгдсөн ухамсарт үйлдэл байдаг бөгөөд сексийн үйл ажиллагааг мөнгөөр үнэлж зарах, түүнийг худалдан авах, зохион байгуулах явдал нь оролцогчдын тодорхой хүрээгээр хязгаарлагдсан нийгмийн далд харилцаа учраас цагдаагийн байгууллагын тоо бүртгэлд шууд дүгнэлт өгөх нь буруу юм. Монгол улсын дээд шүүхээс: Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1-д заасан “Биеэ үнэлэхэд татан оролцуулсан” гэж шунахай болон хувийн бусад сэдэлтээр, хохирогчийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ” гээд Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйлийн 115.1-д заасан “биеэ үнэлэхэд татан оруулсан” гэдгийг нэгэн адил ойлгож, хэрэглэнэ гэж тайлбарлажээ. Хүн худалдаалах ба биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг нь Монгол улсын Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт орох бүрт өөрчлөгдөж байсан байна. 1961 он, 1986 он, 1994 он, 1996 он, 2002 он, 2008 онд Эрүүгийн хуульд нэмэлт

[14] http://news.now.mn/public/show/id1717 Хүний наймаанд биеэ үнэлэгчийг “сонгох” нь ихэсчээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

өөрчлөлт ороход энэ төрлийн хэргийг зүйлчилсэн зүйлүүд нийт 5 удаа өөрчлөгджээ. Үсрэнгүй нийгмийн хөгжилд энэ төрлийн гэмт хэргийн арга улам нарийсч, нуугдмал байдалд шилжих аюултай байгааг анхаарах хэрэгтэй юм.

Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн байдал:

Нийслэлийн хэмжээнд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шийдвэрлэлт, зүйлчлэл, ял, шийтгэл, нотлох баримтыг үнэлсэн байдал, хохирогч хамгаалал, хохирлын нөхөн төлүүлэлт, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийх, хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал, арга замыг тодорхойлох, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход үндэслэл бүхий санал дэвшүүлэх зорилгоор судалгаа хийж үзэхэд Нийслэлийн хэмжээнд 1961 оноос 2010 онд энэ төрлийн гэмт хэрэгт нийт 243 хүнд холбогдох 141 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн бөгөөд үүнээс Биеэ үнэлсэн 57 хэрэгт 78 хүн, Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулсан, биеэ үнэлэхийг зохион байгуулсан 71 хэрэгт 141 хүн, Хүн худалдаалах 14 хэрэгт 25 хүн тус тус ял шийтгүүлсэн байна.[15] Нийт ял эдлүүлэгчдийн 1.5 хувьд албадан ажил хийлгэх ял, 5.4 хувь нь торгох ял, 93 хувьд нь хорих ял оногдуулж, нийт хорих ялыг тэнсэж, 8.5 хувьд нь оногдуулсан хорих ялыг Өршөөл үзүүлэх тухай хуулиар өршөөж, 5.4 хувьд нь хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн, насанд хүрээгүй, жирэмсэн эмэгтэй, эх буюу ганц бие эцэг гэсэн үндэслэлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан байна. Биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт нийт шийтгүүлэгчдийн 40.8 хувьд оногдуулсан хорих ялыг, хорих ангид биечлэн эдлүүлжээ.[16]

Жишээ нь: Н, У нар нь Баянзүрх дүүргийн 6 дугаар хороонд Финлянд саун, массажны газар ажиллуулж байхдаа “саунд массажист авна” гэсэн зар гаргаж

[15] Нийслэлийн шүүхийн эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Б. Сарантуяа “Хүн худалдаалах, биеэ үнэлэхэд бусдыг татан оруулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, гэмт хэргийн талаарх” зөвлөлдөх уулзалтын үеэр тавьсан илтгэлээс

[16] Мөн тэнд

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

ажилд орохоор ирсэн А гэгчийг нийт 2 сарын хугацаанд биеэ үнэлэхэд нь зуучилж, орон байраар хангасан гэмт хэрэг үйлдсэндээ Баянзүрх дүүргийн шүүхийн 2008 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 18 дугаар шийтгэх тогтоолоор Н-д 400 цаг, У-д 304 цаг албадан ажил хийлгэх ял оногдуулсныг хэргийн шинж байдалд тохироогүй, илтэд хөнгөн ял шийтгэсэн гэсэн үндэслэлээр прокурор эсэргүүцэл бичиж анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож байжээ. Монгол улсын дээд шүүхийн тогтоолд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийг тайлбарласан байна. “Хүн худалдаалах” гэдэгт тодорхой төлбөртэйгээр /мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м/ эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож /өрөнд өгөх г.м/ хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно. Монгол улсын Эрүүгийн хуулийн тайлбарт Биеэ үнэлэх гэдэг нь сэтгэл болон дур хүсэлд үндэслээгүй, хариу төлбөртэйгээр өөр өөр хүнтэй бэлгийн харьцаанд удаа дараалан орохыг хэлнэ[17]. Хүнийг худалдаалах гэмт хэргийн хохирогчийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар, төлбөртэйгээр эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож шилжүүлдэг бол биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан, зуучилсан гэмт хэргийн хувьд ийм шинж байдаггүйгээр ялгагдана.

Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хохирогчийн биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсны орлого бүхэлдээ гэмт этгээдийн ашиг болдог бол мөн хуулийн 124 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хувьд ашиг, орлогын тодорхой хэсэг нь гэмт этгээдийн мэдэлд шилжинэ. Түүнчлэн биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулсан, зохион байгуулсан, зуучилсан гэмт хэргийн хохирогчид биеэ үнэлсэн орлогын зарим хэсэг үлддэг бол Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн хувьд ийм шинж байдаггүйгээр ялгагдана.

[17] Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар УБ.,2010 он 329 дахь тал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны судалгаагаар[18] Нийслэлийн хэмжээнд насанд хүрсэн 4640 биеэ үнэлэгч байгаагийн 99.1 хувь нь эмэгтэйчүүд, 0.9 хувь нь эрэгтэйчүүд байна. Нийт биеэ үнэлэгчийн 13.6 хувь нь гудамж талбайд зогсож биеэ үнэлдэг бол 86.4 хувь нь караоке, баар, цэнгээний газар, саун, массажны газруудаас үйлчлүүлэгчээ олж авдаг байна. Биеэ үнэлэгч таван хүн тутмын гурав нь бүрэн дунд боловсролтой, нэг нь дээд боловсролтой байна. Харин бага болон боловсролгүй хүний нийт дүнд эзлэх хувь 2.6 байна.

Судалгаа №1 Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлгээр, байршлаар

Насны бүлэг	Бүгд	Гудамж талбай	Караоке, баар, цэнгээний газар			
			Бүртгэлтэй	Бүртгэлгүй		
			30 хүртэл суудалтай	30 хүртэл суудалтай	30 ба түүнээс дээш суудалтай	Саун массажны газар
Бүгд	4640	633	465	92	470	527
18-20	586	55	39	-	16	38
21-24	1452	132	116	41	140	237
25-29	1017	118	155	19	91	113
30-34	750	112	97	17	98	102
35-39	572	92	39	15	59	27
40-44	189	101	-	-	48	10
45-49	55	23	-	-	18	-
50 ба түүнээс дээш	19	-	19	-	-	-

Биеэ үнэлэгч нь насны байдлаар харьцангуй залуужиж байгаа нь нийгэм дэх ёс суртахуун алдагдаж, амар хялбар аргаар мөнгө ологчдын нийгмийн хүрээ тэлсээр байгаагийн нэг илрэл юм. Аливаа нийгэмд дэг журам сахиж, сайн сайхан

[18] Монгол Улсын үндэсний статистикийн хороо, Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгааны тайлан, УБ, 2010 он,

Хууль зүйн үндэсний хүрээлэн nli.gov.mn

байдлыг бий болгох гол асуудал нь Үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг сахин биелүүлэх, хүчирхийлэл дарангуйлал зэргээс ангид байхыг хэлнэ гэж бодож байна. Дан ганц эмэгтэйчүүд гэлтгүй Үндэсний статистикийн хорооны судалгаагаар нийт биеэ үнэлэгчдийн 0.9 хувь нь эрэгтэйчүүд байна гэсэн дүн гарчээ. Биеэ үнэлэгч эрэгтэйчүүдийн нас нь 18-23 насны залуучууд байна гэсэн нь нийгмийн зохист хандлагыг гажуудуулж байгаа хэрэг юм. Биеэ үнэлэх нь хүмүүсийн зан байдал, өөрийн нийгэмд хандаж байгаа хандлагаас шалтгаалдаг гэж үзэж байна.

Судалгаа №2 Биеэ үнэлэгчдийн тоо, насны бүлгээр

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	Хувь %	Тоо	Хувь %	Тоо	Хувь %
Бүгд	**4640**	**100.0**	**40**	**100.0**	**4600**	**100.0**
18-20	586	12.6	21	5.5	565	12.3
21-24	1452	31.3	5	12.5	1447	31.5
25-29	1017	21.9	-	-	1017	22.1
30-34	750	16.2	2	50	748	16.3
35-39	572	12.3	-	-	572	12.4
40-44	189	4.1	8	20.0	181	3.9
45-49	55	1.2	4	1.0	51	1.1
50 ба түүнээс дээш	19	0.4	-	-	19	0.4

Биеэ үнэлэгчдийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь нийгмийн зохист хандлагыг гажуудуулж байгаа юм. Учир нь ар гэр амьдралаа залгуулж тэжээх гэж сексийн үйл ажиллагааг мөнгөөр үнэлж биеэ үнэлдэг эмэгтэйчүүдээс гадна өөрийн гэсэн орон сууцтай, биеэ үнэлэхээс гадна ямар нэгэн цалин хөлстэй ажил эрхэлдэг эмэгтэйчүүд их байгаа нь нийгмийн бүх давхаргыг хамарсан үзэгдэл болсныг дээрх судалгаагаар харуулж байгаа юм. Нийгмийн өмнө тулгараад буй энэхүү асуудлыг хэрхэн яаж шийдэх, эрх зүйн зохицуулалтыг бий болгох гэсэн асуудлууд гарч байна. Цагдаагийн байгууллагын биеэ үнэлэх явдалтай тэмцэх , таслан зогсоох үйл ажиллагааг оновчтой үр дүнтэй зөв зохион байгуулахын тулд биеэ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

үнэлэх гэдэг ойлголтыг зөв тодорхойлж нийгмийн хамаарал хүрээг нь бүрэн тогтоох ёстой.[19] Биеэ үнэлэх асуудлыг өнөөгийн төвшинд гэмт хэрэгт тооцдоггүй ба харин садар самуунтай тэмцэх тухай хуулиар хориглосон байдаг. Дээрхи үйлдэлд баривчлах арга хэмжээ авч байна.[20] Нийгмийн олон талт харилцаанаас урган гарч буй энэхүү асуудлыг зохицуулах, эрх зүйн асуудалд тулгуурлаж зохист хандлагыг бий болгох хэрэгтэй юм. Зохист хандлагад " Хүний эрх" нэн түрүүнд тавигдах ба Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан бүхий л эрх , эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.[21]

Судалгаа №3

Биеэ үнэлэгчдийн боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	Бүгд		Үүнээс: хүйсээр	
	тоо	хувь	эрэгтэй	эмэгтэй
Магистр	28	0,6	-	0,6
Дээд бакалавр	789	17,0	-	17,2
Дипломын дээд/ тусгай мэргэжлийн дунд	301	6,5	25,0	6,3
Мэргэжлийн анхан шатны	145	3,1	-	3,1
Бүрэн дунд	2960	63,8	65,0	63,8
Суурь	298	6,4	10,0	6,4
Бага	93	2,0	-	2,0
Боловсролгүй	26	0,6	-	0,6
Дүн Хувь		100.0	100.0	100.0
Тоо		4640	-40	4640

[19] Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зарим асуудлууд УБ 2010 49 дахь тал
[20] Мөн тэнд
[21] Хүний эрхийн түгээмэл тунхаглал

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

Биеэ үнэлэгчдийн боловсролын түвшний байдлыг үзвэл таван хүн тутмын гурав нь бүрэн дунд боловсролтой, нэг нь дээд/ бакалаврын боловсролтой байна. Харин биеэ үнэлэгчдийн дунд боловсролгүй, бага боловсролтой хүний эзлэх хувь ердөө 2.6 хувь байгаа сонирхолтой дүн гарсан байна.[22] Дээд боловсролтой биеэ үнэлэгч байна гэдэг нь өнөөгийн нийгмийн ядуурал, ажлын байрны асуудал, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн сэтгэлгээг бий болгож байна. Ямар ч боловсролгүй, биеэ үнэлэхээс өөр аргагүй охид эмэгтэйчүүдийг биеэ үнэлдэг гэдэг байсан бол, боловсролтой мэргэжлээрээ ажиллах чадвартай хүмүүс биеэ үнэлж байгаа нь бэлэнчлэх сэтгэлгээ, амар хялбар аргаар мөнгө олох гэсэн ухамсар төлөвшөөгүй хүмүүс байна гэж дүгнэж хэлмээр байна. Судалгааны баг бусад байгууллагын гүйцэтгэсэн судалгааны тайлан, дүнг ашиглахын зэрэгцээ Цагдаагийн академийн сонсогчдын оролцоотойгоор 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд Нийслэлийн зарим дүүргийн нутаг дэвсгэрт ажиглалтын судалгаа явуулав. Судалгаагаар биеэ үнэлэхэд зонхилон ашигладаг саун, массажийн газар, зочид буудлыг тодорхойлох, түүнчлэн тэдгээрээр үйлчлүүлдэг биеэ үнэлэгчдийн тоог тогтоох оролдлого хийв. Үүнд:

- ХХАА яамны автобусны буудал - 25 – 30 биеэ үнэлэгч,
- Боловсролын Их сургуулийн орчим - 20 – 25 биеэ үнэлэгч,
- “Улаанбаатар” зочид буудал - 30 – 34 биеэ үнэлэгч,
- “Саппоро” үйлчилгээний төв - 23 – 27 биеэ үнэлэгч,
- УИД-ийн урд талбайд - 8 – 13 биеэ үнэлэгч,
- “Дөлгөөн нуур-ын “Мөрөн” зочид буудал - 12 биеэ үнэлэгч,
- “Сити” зочид буудал - 8 биеэ үнэлэгч,
- “”Өгөөмөр” зочид буудал - 11 биеэ үнэлэгч,
- “Ану” зочид буудал - 10 биеэ үнэлэгч байна.

[22] Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо “Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгааны тайлан” УБ., 2010 он

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

Энэхүү тоон мэдээлэл нь нийт биеэ үнэлэгчийн тоог гаргахгүй боловч үйлчлүүлэгч хамгийн олон цугладаг цэг болох нь ажиглагдаж байна.

Биеэ үнэлэгч нар нь зогсдог газар, байрладаг буудал зэргээс хамааран хоногийн хөлс 20000 – 50000 төгрөг, цагийн 8000 – 15000 төгрөгөөр биеэ үнэлдэг бөгөөд тэд өөрсдийн гэсэн очдог буудалтай, хөлсөнд хоногийн 5000 – 25000 төгрөгийг төлүүлдэг байна.

Биеэ үнэлэгч нарыг зөөвөрлөдөг гэх таксины жолоочтой уулзаж ярилцахад 1 таксинд өдөрт 3-4 биеэ үнэлэгчийг тээвэрлэдэг. Нэг хүний 5000 төгрөгөөр бодож таксины үйлчилгээний хөлс авдаг, өдөрт ойролцоогоор 10 орчим такси энэ үйлчилгээнд явдаг. Биеэ үнэлэгч нар дангаараа явна гэж байхгүй. Тэдгээрийн ард зохион байгуулагч нь гэж 50 орчим настай эмэгтэй хүн байдаг гэж байлаа.

Биеэ үнэлэгчдийн насны байдлыг гадна төрхөөс нь авч үзвэл 16 – 35 насны эмэгтэй хүмүүс байх бөгөөд 1 сараас 14 жил биеэ үнэлж байгаа нь ярилцлагын судалгаагаар ажиглагдаж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

3. САДАР САМУУНЫГ СУРТАЛЧИЛСАН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ТОО, ХУУЛЬД ТУСГАСАН БУСАД ШААРДЛАГАТАЙ ТОО БАРИМТ

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино гэж заажээ. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг тараасан борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хил нэвтрүүлсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ[23] гэсэн нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг дахин харахад хүргэж байгаа юм. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд: Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт (цензур) тогтоохгүй гэж заасан. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдахад хориглох зүйлийг дараах байдлаар тодорхойлсон.

7.2.1. албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, цэцэрлэг сургууль, оюутан, сурагчдын дотуур байр, хүнс барааны зах, худалдаа үзвэр үйлчилгээний газар худалдах;

7.2.2 гар дээрээс худалдах;

7.2.3 18 насанд хүрээгүй хүнээр худалдуулах, 18 насанд хүрээгүй хүн худалдах.

Хуулийн 7.2.1 дэх хэсэгт зааснаар “албан байгууллага, гудамж, талбай, хүүхдийн байгууллага, цэцэрлэг, сургууль, оюутан, сурагчдын дотуур байр, хүнс барааны зах, худалдаа, үзвэр үйлчилгээний газар худалдахыг хориглохоор байна. Гэтэл энэ заалт хэрэгждэггүй. Төрийн байгууллагын үүдэнд, хүнс барааны зах дээр

[23] Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ, 2010 он, 326 дахь тал

Үндэсний хүрээлэн Хууль зүйн rli.gov.mn

энэ төрлийн ном зохиол, бичлэгийг худалдсаар байна.[24] Нийгмийн хөгжлийг дагаад хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг хязгаарлаагүй боловч энэ нь эргээд нийгэмдээ сөрөг үр дагаварыг бий болгож болзошгүй байна. Иймд зөрчигдөж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд илтэд хүний сонирхол татах хэвлэлийн тоог хязгаарлах, гудамж талбай дээрх сонин борлуулах цэгүүдэд хяналт тавих, зэрэг арга хэмжээнүүдийг авах нь сөрөг үзэгдлүүдийг бага ч болов хязгаарлагдах болов уу.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, түүний эзлэх хувь

Монголын хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2010 оны нэгдүгээр улирлын байдлаар Монгол Улсын хэмжээнд 383 мэдээллийн хэрэгсэл буюу сонин, сэтгүүл, радио телевиз ажиллаж байснаас 88 хувь нь буюу 337 нь энэ удаагийн мониторингийн судалгаанд хамрагдаж өөрийн байгууллагын тухай мэдээллээ ирүүлжээ. Тогтмол үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудын 50 гаруй хувь нь хэвлэмэл, үлдсэн нь электрон мэдээллийн хэрэгсэл байсан байна. Хэвлэлийн хүрээлэнгээс хэвлэл мэдээллийн талаарх статистик суурь мэдээлэл бүрдүүлэх зорилго бүхий судалгааг эрхлэн явуулж эхэлснээс хойш 10 жил өнгөрч байна. Энэхүү судалгааг тогтмол давтамжтайгаар, урт хугацаанд, ижил аргачлалын дагуу явуулснаар Монголын хэвлэл мэдээллийн өнөөгийн байдлыг бодитоор үнэлж, хөгжлийн чиг хандлаыг тодорхойлох боломжийг бүрдүүлж байгаа юм.

Манай Улсад хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо 2000 оноос эрс нэмэгдэж, хэвлэл мэдээллийн зах зээл дэх хэт нийлүүлэлтийн үе хэмээн тодорхойлохуйц байсан бол 2008 оноос тооны хувьд буурах хандлага ажиглагдаж эхэллээ. Мэдээллийн хэрэгслийн төрөл зүйлийн өсөлт, хөгжил нэгэн зэрэг, нэгэн ижил хэмээр явагдаагүй гэдгийг дурьдах хэрэгтэй. Тодруулбал, 1990-2001 онд сонины,

[24] Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын үүдэнд, Засгийн газрын III дугаар байрны үүдэнд байрны 1 дүгээр давхарт тус тус худалдаж байна. Мөн бөмбөгөр худалдааны төвд нийт 5 цэг байгаа бөгөөд эдгээрт бүгдэд нь эротик сэтгүүл худалдаж байна. Мөн Бөмбөгөр, Нарантуул, Баянзүрх зэрэг худалдааны төвд байрлах DVD худалдах цэгт эротик бичлэг, кино худалдаж байна. Энэ мэдээг Иргэн эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах төсөл /Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль/ 2010 оны ажлын тайлангаас ишлэв.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

2001 оноос радиогийн, 2004 оноос телевизийн, 2005 оноос сэтгүүлийн тоон өсөлтийн үе байсан бол 2008 оноос онлайн мэдээллийн хэрэгслүүд олноор бий болж, харин уламжлалт мэдээллийн хэрэгслийн тоо бага зэрэг буурсан байна[25]. Нийгмийн хэв журмыг хамгаалах газрын судалгаагаар[26] Сонины нийт мэдээллийн 22.7 хувь нь садар самуун үг хэллэг, зураг ашиглан хүчингийн хэргийн талаар уншигчдад сэрэмжлүүлэг өгөх зорилгоор нийтлэгдэж байсан байна. Сэрэмжлүүлэг гэдэг нь хэт илэн далангүй үгээр хүчингийн хэргийн үйлдэл арга барилыг нь тодорхой дүрслэн нийтэлж байгаа нь бусдыг садар самуунд уруу татсан санаа зорилго агуулсан гэхээр сэтгэгдэл төрүүлэхээр байжээ. Түүнчлэн асуудал хөндсөн мэдээлэл 39.4 хувийг эзэлж байгаа ба мөн л садар самуун үг хэллэг зураг ашиглахыг зорьсон байна. Сонины зарын хэсэгт энэ бусармаг байдал тод харагддаг байна. Хүний зүс, өнгө мөнгө заан ажил санал болгох зар нилээд хувийг эзэлдэг. Үүнийг ч бас далд хэлбэрээр садар самуунд уруу татаж сурталчилж байна гэж үзэж болох юм. Жишээ нь Өндөр царайлаг охидыг саунд массажистаар ажилд авна, 25–аас доош насны царайлаг охидыг караокед үйлчлэгчээр авна цалин өндөр гэх зэргийн зарууд нь шууд биш утгаар охид хүүхнүүдийг биеэ үнэлэхийг санал болгож байгаа юм[27]. Манай улсад хүчтэй мэдээлэл бүхий хэд хэдэн сайт байдаг бөгөөд эдгээр нь бүгдээрээ дотроо секс, эротик булантай. Хөгжингүй орнуудад эдгээр буланд орохыг тусгайлсан түлхүүрээр зохицуулдаг бол манай хүн амын дийлэнх нь энэ талын мэдлэг дутмагаас хэн дуртай хүн энэ буланд чөлөөтэй орж мэдээлэл авч байна. Түүнчлэн үүрэн телефоны оператор компаниудаас гар утсанд эротик, секс, садар самууныг сурталчилсан өгүүллэг үлгэр онигоог байнга нэвтрүүлж байна.[28]

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

[25] Монголын хэвлэлийн хүрээлэнгийн мэдээ 2010 он
[26] Нийгмийн хэв журмыг хамгаалах газрын мэдээнээс ишлэв.
[27] Садар самуун явдлыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байгаад хийсэн судалгаа, цагдаагийн байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Нийгмийн хэв журмыг хамгаалах газар
[28] Мөн тэнд

Судалгаа №4

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг аймаг нийслэлийн Засаг даргаас тогтоосон тусгай цэгт худалдана” гэж заасан байдаг. Засаг даргаас тогтоосон тусгай цэг байхгүй байгаа нь энэ хуулийн хэрэгжилт хэрэгжихгүй байгаагийн илрэл юм. Нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд хийсэн судалгаанаас үзвэл:

Дүүргүүдэд байрлах сонин борлуулах цэгийн судалгаа

Дүүрэг	Сонин	Дүрс бичлэг	Нийт тоо
Сүхбаатар	29	-	29
Чингэлтэй	10	13	23
Сонгино-хайрхан	12	14	26
Баянгол			
Багахангай	-		байхгүй
Налайх	-	-	байхгүй
Хан -Уул	-	2	2

Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдан борлуулж байгаа нийт 24 цэг байдаг. Үүнээс 10 нь сонин борлуулах, 13 видео прокат, дүрс бичлэг худалдан борлуулдаг цэгүүд тус тус ажиллаж байна. Мөн насанд хүрэгчдэд үйлчилдэг “Sex shop” дэлгүүр байна. Чингэлтэй дүүргээс ирсэн тайлбарт: Дүүргийн хэмжээнд дагнасан эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэг худалдан борлуулдаг цэг байхгүй бөгөөд дээрх цэгүүд нь бүгд сонин борлуулах тусгай зөвшөөрөлтэй боловч дэргэд нь садар самуун явдлыг сурталчилсан хөрөг зураг бүхий сэтгүүл сонинг давхар зарж борлуулж байна. Энэ үйлдэл нь гудамж талбайд ил задгай худалдаалагдаж байгаа учраас хүүхэд багачууд өсвөр үеийхэнд муу дадал зуршил олгоход нөлөөлж байна. Видео прокат ажиллуулдаг цэгүүдийн хувьд төрөл бүрийн сэдвийн киногоор иргэдэд үйлчилдэг бөгөөд садар самуун явдлыг сурталчилсан кино дүрс бичлэгээр ч мөн үйлчилж байна гэсэн тайлбарыг ирүүлсэн байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

“Секс шоп” нь Чингэлтэй дүүргээс гадна Сонгино-Хайрхан, Баянгол, дүүргүүдэд тус тус үйл ажиллагаа явуулдаг болно. Баянгол дүүрэгт хэчнээн сонин борлуулах цэг, дүрс бичлэг борлуулдаг цэг байгаа эсэхийг тодруулахаар Засаг даргын тамгын газарт нь албан тоот хүргүүлсэн боловч энэ төрлийн мэдээлэл байхгүй болно гэсэн хариу ирүүлсэн. Бидний ажиглалтын судалгаагаар тус дүүрэгт сонин борлуулах 20 гаруй цэг байгаа бөгөөд бүгд эротик хэвлэл ном зохиол зардаг болох нь ажиглалтаар тогтоогдсон. Мөн хамгийн их хүн амтай дүүргийн нэг болох Баянзүрх дүүрэгт ажиглалтын судалгаагаар сонин борлуулах төвлөрсөн цэг байхгүй бөгөөд дэлгүүр дотор, гар дээрээс худалдан борлуулах ажиллагаа явагдаж байна. Эротик чиглэлийн сонингууд 10-14 хоног тутамд гардаг байна. Алаг хорвоо, Янаг хорвоо, Болсон явдал, Далд амьдрал, Маш нууц, Хань, Хонгор зул, Хос хун зэрэг сонингууд гардаг байна. Мөн монголын анхны эротик сэтгүүл “Үдшийн шивнээ” гэсэн сэтгүүл гарч байна. Нийслэл хотын хэмжээнд 2011 оны эхний улирлын байдлаар нийт: Телевиз 32, Радио 106, Сонин, сэтгүүл 317 үйл ажиллагаа явуулж байна[29].

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

[29] Үндэсний Статистикийн хорооны 2011 оны 5 сарын 10-ны өдрийн мэдээнээс

4. САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Түүхэн тойм: Биеэ үнэлж явалдах байдал эрт үеэс улбаатай аж. Манай эриний өмнөх VI зууны Афинд Солон эрэгтэйчүүдийн хэрэгцээг хангах, гэрлэсэн эмэгтэйчүүдтэй бэлгийн харьцаанд орохоос сэргийлэх зорилгоор биеэ үнэлэх явдлыг ил болгож, орон байр нээхийг зөвшөөрчээ. Гэхдээ биеэ үнэлж явалдах байрыг төрийн мэдэл, хамгаалалтанд авч, биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийг гадаад төрх байдлаараа бусдаас ялгарч байхыг шаардахын гадна олсон орлогын тодорхой хэсгийг улс авдаг байжээ.[30]

Эртний Ромд биеэ үнэлж явалдах газар /эмсийн хүрээлэн/ олон байсан тухай түүхчид тэмдэглэн үлдээжээ. Амстердам дахь алдарт “Улаан дэнлүүний гудамж /хороолол/” бүр XIV зуунаас эхлэлтэй бөгөөд XVII зуунд Голландыг дэлхийн худалдааны томоохон төв байх үед хууль ёсоор үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн чухал газар болж, засаг захиргааны байцаагч түшмэл үйлчлүүлсэн далайчдын тоогоор тус нэгжээс татвар авдаг байжээ[31].

Эртний өндөр соёлтой Хятад, Энэтхэг, Япон зэрэг дорны улсуудад тухайн түүхэн цаг үеийн нийгмийн ёс суртахуун, шашин шүтлэг, хаад, ноёдын явуулж байсан бодлого зэргээс шалтгаалан биеэ үнэлж явалдах асуудалд эерэг, сөрөг байдлаар хандаж ирсэн байна.

Италийн криминологич Чезаре Ломброзо биеэ үнэлж явалдах, түүний гэмт явдалтай хэрхэн холбогдохыг анхлан судалж, “Гэмт хэрэгтэн бүсгүй ба биеэ үнэлэн явалдагч” гэсэн ном бичжээ.[32] Тэрээр “биеэ үнэлэхийг”-ыг ёс суртахууны солиорлын нэг хэлбэр гэж үзэж, гудамж, эмсийн хүрээлэнд биеэ худалдахаас гадна бие үнэлж явалдах дараах хэлбэр байдаг гэжээ. Үүнд:

- Соёл иргэншлийн: гэр бүл болох ёсон нийгэмд бүрдээгүй буюу эхнэрүүд нийтийн байх /бушменууд, каледончууд г.м./

[30] http://www.owl.ru/content/docs/world/p55270.shtml
[31] http://www.memoid.ru/search/?x=0&y=0&memoidsearch=проституции
[32] Cezare Lombroso. Criminal woman, the prostitute,and the Normal woman 1895 page 35

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nlrlgov.mn

- Зочломтгой зан үйлийн: ирсэн зочдод эхнэрээ санал болгох /Марианы болон Филиппиний зарим арлын уугуул оршин суугчид/
- Шашны зан үйлийн: шашны зан үйлийн ёс гүйцэтгэж замбараагүйгээр хурьцал үйлдэх
- Улс төрийн: биеэ үнэлэгчийг ашиглан улс төрийн зүтгэлтэнд нөлөөлөх
- Эстетик: элит түвшний төлөөлөгчдийн нууц амраг болж, тэднээр тэтгүүлж байх.[33]

Эдүгээ дэлхийн улс орнуудад биеэ үнэлж явалдахыг хатуу хориглох нь тийм ч сайн үр нөлөөтэй гэж үзэхгүй байна.

Ингэж үзэхэд хүрсэн шалтгааныг Их Британийн хүний эрхийн байгууллагын ажилтан Жерри Макилсон “Биеэ үнэлэн явалдаж буй нь бус, харин түүнийг хориглож буй нь дээд зэргийн муу зүйл юм. Биеэ үнэлэхийг хориглосон тэр газарт авлига янз бүрийн хэлбэрээр цэцэглэж,... засаг төр нь секс үйлчилгээг хориглосон шийдвэрээ зөөлрүүлэхээс аргагүй байдалд хүрч байна”[34] гэж бичсэнээс төсөөлөн ойлгох боломжтой. Дэлхийн улсуудыг биеэ үнэлж явалдах үзэгдэлд хэрхэн хандаж, хуулийн ямар зохицуулалт үйлчилж буйгаар нь дараах байдлаар 3 ангилдаг.

- Биеэ үнэлж явалдахыг хориглосон хуулийн зохицуулалттай /Албани, Израил, Исланд, Камбож, Литва, Норвеги, ОХУ, Монгол, Швед, Украйн, Тайланд, АНУ-ын Невада муж улсаас бусад муж, лалын шашинтай олонхи улсад /
- Биеэ үнэлж явалдахыг тодорхой хэмжээгээр зөвшөөрсөн хуулийн зохицуулалттай /Австри, Австрали, Бельги, Голланд, Унгар, Шинэ Зеланд, Швейцар, ХБНГУ, Тайван, Турк, зэрэг/
- Биеэ үнэлэгчийг бус, харин худалдан авагчид хариуцлага хүлээлгэх зохицуулалттай /Швед, БНСУ, Литва/ хоёуланг нь шийтгэдэг/зэрэг/ [35]

[33] Мөн тэнд
[34] http://en.wikipedia.org/wiki/Prostitution дэлгэрүүлэн харна уу.
[35] http://en.wikipedia.org/wiki/Prostitution дэлгэрүүлэн харна уу.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

1. Биеэ үнэлж явалдахыг хориглосон хуультай улсууд

Эдгээр улс /Шведээс бусад/-д биеэ үнэлж явалдах үзэгдлийг хориглосноор таслан зогсоож, багасгаж чадаагүй. ОХУ-ын Төрийн думын Иргэн, Эрүүгийн болон Арбитражийн байцаан шийтгэх ажиллагааны тухай хууль тогтоомжийн хорооны ажлын хэсгийн бэлтгэсэн "ОХУ-д хүнийг худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэж буй тухай" илтгэлд хуулийн байгууллагуудын мэдээгээр ОХУ-д ойролцоогоор 400,000 эмэгтэй биеэ үнэлж явалдагч байгаа ба секс үйлчилгээ үзүүлэх бизнест 500,000-1000,000 хүнийг хамарч байгаа гэсэн тоо баримт дурджээ.[36] Биеэ үнэлсэн, явалдсан аль алийг цаазаар авах ял оноодог. Иранд гэхэд л 2007 онд албан ёсны мэдээгээр 300,000 /биеэ үнэлэгч/ бүртгэгджээ. Гэхдээ энэ "ажил"-ыг гэрлэж нэг шөнө унтаад маргааш нь гэрлэлтээ цуцлуулах аргаар гүйцэтгэдэг байна. Тайланд, Камбожид ихээхэн газар авсан секс-жуулчлалын үйлчилгээнд биеэ үнэлэх явдал үндсэндээ ил явагддаг ажээ.

2. Биеэ үнэлж явалдахыг тодорхой хэмжээгээр зөвшөөрсөн хуулийн зохицуулалттай улсууд

Эдгээр улсад биеэ үнэлж явалдахыг хуулиар тогтоосон журмын хүрээнд зөвшөөрсөн байдаг. Тухайлбал:

- ***ХБНГУ-д***. Энэ асуудлыг 2002 оноос ил болгохдоо зөвхөн Европын Холбооны иргэдэд зөвшөөрч, тэдгээр нь нийгмийн халамж /өндөр насны тэтгэврийг оруулан/ болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамаарах болж, биеэ үнэлж явалдахыг ёс зүйгүй явдал гэж шүүмжилсэн болон үйлчлүүлээд хөлсөө төлөөгүй этгээдийг шүүхийн журмаар хариуцлагад татах боломжтой болсон байна. Биеэ үнэлэгчид үйлдвэрчний эвлэлд нэгдсэн байна[37].

- ***Их Британи.*** Биеэ үнэлэгчид гудамжинд эрэгтэйчүүдийг өдөж хоргоох, түүнчлэн биеэ үнэлж явалдахыг зохион байгуулах, зуучлах, эрчүүд эмэгтэйчүүдийг "оролдох" зэрэг үйлдэлд эрүүгийн хариуцлагад татах боломжтой. Тус улсын Дотоод явдлын яам эмсийн хүрээлэнгийн үйл ажиллагааг ил болгохыг 2004 оноос

[36] http://en.wikipedia.org/wiki/Prostitution дэлгэрүүлэн харна уу.
[37] Мөн дээрх сайтаас дэлгэрүүлэн харна уу.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

эхлэн санал болгосон ч одоогоор дэмжлэг олоогүй байна. Түүнчлэн тус улсад үйл ажиллагаа явуулдаг секс-ажилтнуудын олон улсын үйлдвэрчний эвлэл –IUSW 2003 оноос Их Британид томоороо гуравт эрэмбэлэгдэх үйлдвэрчний эвлэл болох GMB-ийн бүрэлдэхүүнд орох болж, бусад ажил, хөдөлмөр эрхлэгчдийн нэгэн адил элдэв хөнгөлөлтөд хамрагдахын төлөө хөдөлгөөн өрнүүлж байгаа ажээ.[38]

- ***Грек.*** Гудамжинд биеэ үнэлэхийг зөвшөөрсөн. Биеэ үнэлэгч /эрэгтэй, эмэгтэй/ хэн боловч гэр бүл болохыг хориглодог ба хэрэв гэр бүлтэй болвол олгосон зөвшөөрөл /биеэ үнэлж явалдах/-ийг хүчингүй болгодог.

- ***Итали.*** Секс үйлчилгээг хувийн журмаар үзүүлэхийг хориглодоггүй ч биеэ үнэлж явалдахыг зохион байгуулах /дууч эмсийн хүрээлэн байгуулах зэрэг/-ийг хориглосон. Түүнчлэн зөвхөн биеэ үнэлж явалдахаас олох орлогоор амь зуухыг хориглосон ч хуулийн энэ заалт байнга зөрчигддөг ажээ. 2002 оноос дууч эмсийн хүрээлэнг зөвшөөрөх тухай хуулийн төсөл Засгийн газар өргөн мэдүүлсэн, 2007 онд Италийн коммунист нам Ром хотноо “сексийн парк”-нэртэй “ тусгай ажлын бүс биеэ үнэлэгчдэд зориулан байгуулах санал гаргасан нь хэлэлцэгдэж байгаа ажээ.

- ***Турк.*** Биеэ үнэлж явалдахыг албан ёсоор зөвшөөрсөн. Гэхдээ дууч эмсийн хүрээлэнг зөвшөөрч, биеэ үнэлэхээр гудамжинд зогсохыг хориглосон. Эмсийн хүрээлэн байгуулахыг хүсэгч төрийн зохих байгууллагад хандаж зөвшөөрөл хүсэх ба зөвшөөрөл авсан тохиолдолд эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн байгууллагын хяналт, орон нутгийн цагдаагийн хамгаалалтад ордог. Биеэ үнэлж явалдахыг хүссэн эмэгтэй мөн зөвшөөрөл авах ба ДОХ болон өнгөний өвчний шинжилгээ байнга /долоо хоног тутам/ өгөх, эмсийн хүрээлэнд “ажиллах” үүрэг хүлээдэг. Биеэ үнэлж явалдахыг ийнхүү хуулиар зохицуулсан ч хууль бусаар биеэ үнэлэгч маш олон, ялангуяа гадаадын иргэд хүний наймааны золиос болж маш хүнд нөхцөлд дээрх ажлыг гүйцэтгэж байдаг.

- ***Голланд.*** Биеэ үнэлэх явдал энэ улсад 2000 оноос бүрэн чөлөөтэй болсон гэх боловч үнэн хэрэгтээ аль эртнээс харьцангуй чөлөөтэй байсан учраас хуулийг хэлбэрийн төдий шийдвэр гэж үздэг. Амстердам дахь “улаан дэнлүүний хороолол” зэрэг нь гадны жуулчдын олноороо зорьж ирдэг, ихээхэн орлого оруулдаг газар

[38] Мөн дээрх сайтаас дэлгэрүүлэн харна уу.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

учир түүнийг хаахыг жуулчид төдийгүй нутгийн оршин суугчид эсэргүүцдэг. Түүнчлэн биеэ үнэлэгчдийг шилэн хоргоноос гаргаснаар тэдгээрийн хүчирхийлэл, мөлжлөгөөс хамгаалагдсан байдал дордоно гэж үздэг байна. Гэвч Амстердам хотын захиргаа сүүлийн жилүүдэд биеэ үнэлж явалдах үзэгдлийг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээ авсаар байна. Тухайлбал, биеэ үнэлдэг газрууд болон биеэ үнэлэгчдийг лицензтэй болгож, тоог нь цөөрүүлж, биеэ үнэлж явалдахыг зөвшөөрөх насны хязгаарыг 18-23 нас болгон багасгаж, 4:00-8:00 цагийн хооронд биеэ үнэлж явалдахыг хориглосон байна.

3. Биеэ үнэлэгчийг бус, худалдан авагчийг хариуцлагад татах хуулийн зохицуулалттай улс.

- Анхдагч нь Швед улс. Энэ улсад биеэ үнэлж явалдахыг эмэгтэйчүүд, хүүхдүүдэд эрчүүдийн зүгээс үзүүлж буй хүчирхийллийн хүнд хэлбэрт тооцож, хувь хүнд болон нийгэмд бүхэлд нь ноцтой хор хохирол учруулдагын хувьд нийгмийн энэхүү гаж, хортой үзэгдэлтэй төрийн бодлогоор хатуу тэмцэл явуулдаг байна. Тухайлбал: *"Эмэгтэйчүүдийн эрх чөлөөний тухай"* 1999 оны 1 дүгээр сараас мөрдсөн хуулиар биеэ үнэлж явалдахыг эмэгтэйчүүдийг хүчирхийлж буй нэг хэлбэр гэж үзжээ.[39] *"Секс үйлчилгээг худалдан авахыг хориглох тухай"* 1998 оны хуулиар шан хөлс өгөх замаар бусдыг тохиолдлын бэлгийн харилцаанд уруу татсан этгээдийг хэрэв энэ үйлдэлд нь Шведийн Эрүүгийн хуулиар шийтгэл ногдуулахааргүй байвал секс үйлчилгээ худалдан авсанд яллаж, мөнгөн торгууль төлүүлэх буюу 6 сар хүртэл хугацаагаар шоронд хорихоор шийтгэж болохоор заасан бөгөөд биеэ үнэлсэн эмэгтэй нь эрүүгийн хариуцлага хүлээхгүй ажээ. Өөрөөр хэлбэл, биеэ үнэлж явалдах нь гэмт хэрэг бус, харин секс үйлчилгээг худалдан авсан үйлдэл /завдалтыг гэмт хэрэгт тооцдог/ нь гэмт хэрэг болдог байна. Шведийн цагдаа болон нийгмийн үйлчилгээний албаны мэдээгээр дээрх хуулиудын үр дүнд гудамжинд биеэ үнэлэх байдал мэдэгдэхүйц багасчээ.

[39] http://www.owl.ru/content/docs/world/p55270.shtml

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

Шведийн хуулийн “бараа худалдсаныг бус, худалдан авсныг шийтгэдэг” зохицуулалтыг бусад улс сонирхон судалж, дотооддоо нэвтрүүлэх явдал нэмэгдэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

4. САДАР САМУУН ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ТАЛААР БНСУ, ЯПОН УЛСЫН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

БНСУ-ын хуулийн зохицуулалт

Биеэ үнэлж явалдах үзэгдлийн шалтгаан нөхцөл Өмнөд Солонгост өвөрмөц онцлогтой. Тус улсыг Японы колончлолд байх үед олон мянган солонгос эмэгтэйг япон цэргийн хэрэгцээг хангуулахын тулд хүчээр “биеэ үнэлэгч” болгож байсан. Дэлхийн хоёрдугаар дайны дараа тус улсад байрласан АНУ-ын цэргийн албан хаагчдын “үйлчилгээ”-нд мөн олон мянган охид төрийн дэмжлэг, зохион байгуулалтын дор “ажиллаж”, биеэ үнэлэх явдал маш их газар авсан гэж үздэг. Солонгос эмэгтэйчүүдийн хөгжлийн институтын судалгаагаар 2007 онд секс худалдааны орлого 14 триллион вон буюу 13 тэрбум долларт хүрсэн нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1.6 хувийг эзэлж байна.

Криминологийн судалгааны институтын тайланд “260.0 мянган эмэгтэй буюу 25 залуу эмэгтэй тутмын нэг нь секс бизнест аль нэг хэлбэрээр өртдөг” гэжээ. Түүнчлэн тус институтын өөр нэгэн илтгэлд “20 дээш насны эрчүүдийн 20 хувь нь сард 4-өөс доошгүй удаа секс-үйлчилгээнд мөнгө төлдөг” гэж дурджээ. 2004 онд Өмнөд Солонгост биеэ үнэлж явалдах, түүнийг зохион байгуулах, зуучлахтай тэмцэхэд чиглэсэн хууль гаргасан ба энэ хуулиар эмэгтэй хүнийг худалдах, худалдаж авахыг хориглож, зөрчсөн этгээдэд их хэмжээний торгууль ногдуулах, эсхүл 10 жил хүртэл хорих ял ногдуулах болсон байна. Дээрх хуулийн дагуу 2007 онд 35.0 мянган үйлчлүүлэгчийг мөрдөж мөшгөсөн нь 2003 оныхоос 2.5 дахин их байна. “Биеэ үнэлэхэд зуучлах, түүнд ногдуулах шийтгэлийн тухай” дээрх хуулийг 2010 онд шинэчлэн найруулсан бөгөөд 4 бүлэг, 28 зүйлтэй.

Нэгдүгээр бүлэгт:

Хуулийн зорилт, нэр томъёо, төрийн хүлээх үүрэг, холбогдох бусад хуулийн тухай заасан.

Үүнд, Садар самуун явдлыг эмэгтэй хүн биеэ үнэлж явалдах төдийхнөөр хязгаарлалгүй, “хүний наймаа, бэлгийн мөлжлөг” зэрэг даяарших хандлагатай байгаа “том” асуудлын хүрээнд хуулийн зорилтыг тодорхойлж, бэлгийн

Хууль зүйн үндэсний хүрээлэн nli.gov.mn

хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд /хохирогчийн/ эрхийг хэрхэн хамгаалах, үүнд төр ямар үүрэг хүлээхийг хуульчилсан байна.

Хоёр, гуравдугаар бүлэгт:

Хохирогчийг хамгаалах нэртэй энэхүү бүлэг нь бэлгийн мөлжлөгт өртсөн хохирогчийг хариуцлагад татахгүй болохыг зааж, энэ төрлийн хэргийг шалгах журам, ийнхүү шалгах явцад болон цаашид хохирогчийн эрхийг хэрхэн хамгаалах асуудлыг зохицуулжээ.

Дөрөвдүгээр бүлэгт:

Биеэ үнэлэх, зуучлах, хүчирхийлэх, худалдах болон үүнтэй адилтгах олон гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тодорхойлжээ. Гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн этгээдийг хамгаалах, шагнаж урамшуулах зохицуулалт тусгасан байна.

Энэхүү хуулиас гадна БНСУ-д:

- Өсвөр насны хүүхдийг хамгаалах тухай хууль,
- Өсвөр насны хүүхдийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах тухай хууль,
- Онц хүнд гэмт хэргийн гэрчийг хамгаалах тухай хууль,
- Биеэ үнэлэхтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тухай хууль,
- Байцаан шийтгэх ажиллагааг эрчимжүүлэх тухай хууль,
- Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах тухай хууль,
- Хамгаалалтын арга хэмжээг зохицуулах тухай хууль зэрэг олон хуулиар садар самуун явдалтай тэмцэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг байна

Япон Улсын эрх зүйн зохицуулалт.

Биеэ үнэлж явалдахыг албан ёсоор 1950-аад оноос хуулиар хориглосон. Эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй “Биеэ үнэлж явалдахаас урьдчилан сэргийлэх тухай” хууль / 1956 он/ нь 4 бүлэг, 40 зүйлтэй.

Нэгдүгээр бүлэгт: “Нийтлэг үндэслэл” хэмээх энэ бүлэгт хуулийн зорилт, ойлголт, баримтлах зарчмыг тусгасан. Үүнд:

- Зорилтод дээрх хуулиар зохицуулах харилцааг тодорхой тусгаж өгсний дотор биеэ үнэлж явалдсан эмэгтэйчүүдийг хамгаалах, хүмүүжүүлэх, нийгэмд буцаан оруулах талаар тусгасан нь чухал ач холбогдолтой болжээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

- ***Биеэ үнэлж явалдахыг, мөн биеэ үнэлэгчээр үйлчлүүлэхийг адил хэмжээнд хориглосон*** /3 дугаар зүйл/.

Хоёрдугаар бүлэгт: "Эрүүгийн хариуцлага" энэ бүлэгт биеэ үнэлж явалдах гэмт хэргийн диспозиц, санкцийг тодорхойлсон. Үүнд:

- Биеэ үнэлж явалдах, түүнд зуучлах, орон байр бэлтгэх зэрэг нийт диспозицийг тодорхойлсон нь хуулийг хэрэглэхэд маш дөхөмтэй болгожээ.[40]
- Ялыг маш ялгавартай тогтоосон
- Завдсанаар энэ төрлийн гэмт хэрэгт хамаарах тухай хэд хэдэн заалт байна. Түүнчлэн Японы Эрүүгийн хуульд заасан зарим хөнгөлөлт энэ төрлийн хэрэгт хамаарахгүй болохыг хуульд шууд зааж өгсөн байна.

Гуравдугаар бүлэгт: "Засан хүмүүжүүлэх ял" гэмт этгээдийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэх гэсэн утга агуулгатай зохицуулалт тусгасан. Үүнд:

- Ял эдэлж буй эмэгтэйчүүдийг нийгэмшүүлэхтэй холбогдсон бидний хувьд маш сонирхолтой зохицуулалт тусгажээ. Энэ нь биеэ үнэлэгчдийн хувьд төдийгүй Эрүүгийн хуулийн шинэчлэлийн нэг чухал чиглэл /сэдэв/ байх боломжтой.

Дөрөвдүгээр бүлэгт: Урьдчилан сэргийлэх ба нийгэмд дасгах үйл ажиллагааны талаар тусгасан. Эмэгтэйчүүдийг биеэ үнэлэхээс сэргийлэх, нийгэмд дасан зохицоход нь туслах чиглэлээр ажиллах эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төв, түүний эрх хэмжээ, үйл ажиллагааны санхүүжилт, төрөөс үзүүлэх бусад дэмжлэгийн талаар олон чухал зохицуулалт тусгасан нь анхаарал татаж байна. Хуулийг хавсаргав.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

[40] Prostitution prevention law (Law № 118,May 24,1956) EHS LAW BULLETIN SERIES

ДҮГНЭЛТ

Хууль зүй, дотоод хэргийн яаманд хэрэгжүүлж буй “Иргэн, эдийн засгийн хууль тогтоомжийн давхардал, зөрчил, хийдлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах” төслийн хүрээнд садар самуун явдалтай тэмцэх асуудалд шууд хамаарах 11 хуульд давхардал, хийдэл, зөрчлийн талаар харьцуулан судалжээ.

Уг судалгааны тайланд хуулийн зохицуулалтын давхардал болон зөрчлийн талаар дурдсан байна. Тухайлбал: Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглох зохицуулалт нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд давхардсан, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд гадаадын иргэн садар самууныг сурталчлах, түгээн дэлгэрүүлэхийг хориглосон байх бөгөөд энэ нь Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан зохицуулалттай агуулгын хувьд ижил. Садар самуун явдалтай тэмцэх талаар дээрх хуулиудаар тогтоосон журмыг зөрчсөн нэг ижил үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагыг өөр өөр байдлаар тогтоосон, түүнчлэн Эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж тооцогдсон үйлдлийг Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд захиргааны журмын зөрчилд тооцсон зэрэг хуулийн зохицуулалтын давхардал, зөрчил бага бус байгааг тайланд мөн дурджээ.

Дээрх судалгааны тайланд дурдсаныг давхардуулалгүйгээр мөн хууль, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд эрх зүйн зөрчил гэмт хэрэг, захиргааны журмын зөрчилийн диспозиц, санкцийг харьцуулан, биеэ үнэлж явалдах асуудлаар тухайлан оруулсан зохицуулалт, тэдгээр нь хэрхэн үйлчилж буйг судалж үзэв. Үүнд:

1. Үндэсний хууль тогтоомжид биеэ үнэлж явалдахыг хориглосон хэдий ч түүнийг зөрчсөн тохиолдолд гэм буруутай этгээдэд зөвхөн захиргааны хариуцлага ногдуулахаар заажээ. Харин биеэ үнэлэгчээр үйлчлүүлсэн этгээдийн хувьд хохирогчийн 16 насанд хүрээгүйг нь мэдсээр байж хурьцал үйлдсэнээс бусад тохиолдолд ямар нэг хариуцлага хүлээхээргүй байна. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч

Үндэсний хууль зүйн хүрээлэн nlri.gov.mn

буюу биеэ үнэлж явалдах эрэлт хэрэгцээг “агуулагч” этгээд хариуцлагаас гадуур үлдэхээр байна.

2. Садар самуун явдалтай тэмцэх талаарх хууль тогтоомжид захиргааны журмын нэг адил зөрчилд ногдуулах шийтгэл /торгууль/-ийн хэмжээг өөр өөр тогтоосон нь буруу байна.

3. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүн, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиар тогтоосон захиргааны журмын зөрчлийн бүрэлдэхүүнийг нэг адил томъёолсон нь эдгээр хэм хэмжээг хэрэглэхэд бэрхшээлтэй болгожээ. Тухайлбал, Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-ийн “биеэ үнэлж явалдах нөхцлөөр хангаж, ...тусгай байр, тээврийн хэрэгслээр зориуд үйлчлэх, зуучлахыг хориглоно” гэсэн заалт, Эрүүгийн хуулийн 124 дүгээр зүйлийн 124.2-ын “биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхэд зуучилсан, тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлсээр үйлчилсэн” гэсэн заалт адил учир ***ЭХ-ийн 124 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэж шалгавал буруутай этгээд 5 жил хүртэл хорих ялаар шийтгүүлэх, харин захиргааны журам зөрчсөн гэж үзвэл захиргааны хэрэг үүсгээд 35.0-50.0 мянган төгрөгөөр торгуулах магадлалтай.*** Эрх бүхий албан тушаалтан дээрх хоёр хувилбарын алийг ч өөрийн дур зоргоор хэрэглэж болно.

4. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “энэ хуулийн 5.1, 5.2 ***/5.1. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно, 5.2. Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, зураг, болон бусад зүйлийг бэлтгэх,. тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно***/-т заасан зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн заалт Эрүүгийн хууль болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн эрүү, захиргааны хариуцлагаас чөлөөлөх ерөнхий зарчим, нийтлэг зохицуулалтад нийцэхгүй байна. Түүнээс гадна садар самууныг сурталчилсан тухайд захиргааны хариуцлага ногдуулах бусад хуулийн зохицуулалтыг дээрхтэй хэрхэн уялдуулах,

Үндэсний хүрээлэн
Хууль зүйн
nlrc.gov.mn

“эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” гэсэн тодотголыг ямар утгаар ойлгох нь тодорхой бус.

5. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуульд зааснаар ногдуулах захиргааны хариуцлага /шийтгэл/ үр нөлөөг хангалттай бус гэж үзэж болно. Учир нь, болзошгүй торгуулийн хэмжээг журам зөрчиж олсон орлогын хэмжээтэй зүйрлүүлэхийн аргагүй. Олсон орлогыг хураах тухай хуулийн заалт бий ч түүнийг хэрэгжүүлж олсон орлогын хэмжээг тодорхойлох бодит боломж байхгүй. Иймд нэг удаа биеэ үнэлж явалдаад олох орлогоор хэд хэдэн удаагийн шийтгэлийг хаах боломжтой учир дахин дахин зөрчил гаргахаас эмээхээ больсон байна.

6. Бүхэлд нь авч үзвэл ***Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль хэт ерөнхий зохицуулалттай, түүнийг хэрэгжүүлж, биелэлтийг тооцоход түвэгтэй, хамгийн чухал асуудал болох биеэ үнэлж явалдахтай хэрхэн тэмцэх, бэлгийн хүчирхийлэл, хүний наймаанд өртсөн эмэгтэйчүүдийг яаж хамгаалах, хэрхэн нийгэмшүүлэх зэрэг асуудлыг орхигдуулсан*** гэж дүгнэж болохоор байна.

7. Монголын үндэсний хууль тогтоомжид үйлчлүүлэгч хариуцлага хүлээхгүй байх боломжтой.

8. Хуулийн биелэлтийг хангахдаа хүний эрх, эрх чөлөөг зөрчихөөс сэргийлэх тухай чухал заалтыг оруулсан байна. Энэ заалтыг цагдаагийн байгууллага биеэ үнэлж явалдсан этгээдийн гаргасан зөрчлийн талаар түүний ажиллаж, суралцаж байгаа газрын захиргаанд, ажил, сургуульгүй буюу гэрийн тодорхой хаяггүй бол оршин суугаа газрын харъяа сум дүүрэг баг хорооны Засаг даргад, эсхүл нийтэд албан ёсоор мэдээлнэ гэсэн. “Садар самуун явдалтай тэмцэх тухай” Монгол Улсын Үндсэн хуулийн заалттай харьцуулан үзвэл хүний нэр төр, эрх, эрх чөлөөнд хэрхэн, яаж хандаж байгаад дүгнэлт хийж болохоор байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

Санал

1. Садар самуун явдал, түүний дотор биеэ үнэлж явалдахтай тэмцэх төрийн бодлогыг үндэслэлтэй тодорхойлох шаардлагатай. Дэлхийн улсууд биеэ үнэлж явалдахыг:

- хориглох / чанга, харьцангуй сул/,
- хяналтын дор зөвшөөрөх / харьцангуй чөлөөтэй, бусад ажил мэргэжлийн нэгэн адил авч үздэг/,
- хэрэглэгч буюу төлбөр төлөгчийг хариуцлагад татах,
- биеэ үнэлэгч, хэрэглэгчийг аль алийг нь хариуцлагад татах байдлаар асуудлын голыг олж хуулиар зохицуулсан байна.

Бусад улсын хуулийн зохицуулалтын ерөнхий хандлага нь хатуу хориглох гэхээсээ илүүтэй төрийн хяналтын дор зөвшөөрөх, үүнийхээ сөрөг үр дагавар, болзошгүй эрсдлийг дээд зэргээр багасгах бодлого баримтлахын зэрэгцээ "хүний наймаа, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл"-тэй тэмцэх чиглэлээр хуулийг боловсронгуй болгоход анхаарах болжээ.

2. Монгол Улсад садар самуун явдал, түүний дотор биеэ үнэлж явалдахыг хуулиар хориглосон боловч баталсан хуулийг мөрдөж хэрэгжүүлэхэд анхааралгүй учраас уг хуулийн үр нөлөөний талаар ярихад учир дутагдалтай. Гэвч хууль тогтоогчийн баталсан байдлаар нь ч авч үзсэн дээрх хуульд шүүмжлэлтэй хандах зүйл багагүй болохыг тайланд дэлгэрэнгүй дурдсан. Иймд энэхүү хуулийг боловсронгуй болгох гэхийн оронд ихээхэн өөр үзэл баримтлалтай, шинэ хууль гаргах нь зүйтэй гэж үзнэ.

3. Япон улсад муж бүр нь эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх төвтэй байдаг. Үүнийг дотооддоо нэвтрүүлэх,

4. Биеэ үнэлэх охид эмэгтэйчүүдийг энэ төрлийн үйл ажиллагаанд ашиглах явдал манай нийгэмд бодитой оршиж байна. Манай улсын 50 дээш хувийг эзэлж буй эмэгтэйчүүдийн хүний эрх, жендерийн тэгш эрх, тэгш байдал, хүний аюулгүй байдал бүрэн утгаараа бодит амьдрал дээр хэрэгжихгүй байгаа явдал юм. Иймд хууль сурталчлах, хувь хүнийг багаас нь аливаа эрсдэл халдлагаас өөрийгөө

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН nli.gov.mn

хамгаалах чадвартай болгох чиглэлээр дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрт оруулах

5. Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн субъектийн насыг тодорхой болгох, үүнийг Эрүүгийн хуульд “16 насанд хүрээгүй хүнийг татан оролцуулсан бол” гэж заасан ба Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулиар “18 насанд хүрээгүй хүнээр худалдуулсан” гэдгийг тодорхой болгож насыг зөв тогтоох

6. Мөн Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн объектив талын шинжүүд болох 4,1-ийг, 4,2-ийг, 5.1, 5.2, 5.3, 6.2, 7 дугаар зүйл, 8.1,3 хуулиуд давхардал үүсгэж байна. Тус хуулийн 4,5,6,7 дугаар зүйлүүдийг өөрчлөх;

7. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 13.2.3 энэ хуулийг 5.1-ийг зөрчсөн бол садар самууныг сурталчилж олсон орлогыг хурааж, гэм буруутай албан тушаалтныг 40000-60000 хүртэл төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагыг 100000-150000 хүртэл төгрөгөөр торгох, энэ зөрчлийг нэг жилийн дотор давтан гаргасан бол хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг зогсоох, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 41 дүгээр зүйл Садар самууныг сурталчилсан, түүнчлэн өнгөний өвчний үзлэг, эмчилгээнээс зайлсхийсэн, эмчилгээг тасалсан, өнгөний өвчин халдаагчаа нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 10000 хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэл ногдуулна.

Садар самууныг сурталчилсан тохиолдолд хүлээлгэх хариуцлага нь хоёр хуульд өөр өөр байдлаар зохицуулсан байна. Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 13.2.3-ийг өөрчлөх;

8. Садар самуун явдлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тохиолдолд гэм буруутай мэдээллийн байгууллагад хүлээлгэх хариуцлага нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.3 дахь хэсэгтэй зохицуулалт нь ижил тул Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 13.2.3 дахь заалтыг өөрчлөх.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn

Тайлан бичсэн:

ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрхлэгч Ж. Энхнасан

ХЗҮХ-ийн Эрдэм шинжилгээний дэд ажилтан Х. Өсөх

Цагдаагийн академийн Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй
ба криминалистикийн тэнхимийн багш Г. Амаржаргал

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
nli.gov.mn